



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 07 сарын 22 өдөр

Дугаар А/253

Сүхбаатар сум

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 "а", 29.1.6 "г", 29.2, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.4, 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсад атар газар эзэмших их аяны эхлэлд газар тариалангийн Орхон Сангийн аж ахуй эмхлэн байгуулагдаж, хөгжил дэвшлийн баялаг бахархал дүүрэн түүхтэй эхэлсэн Орхон сумын 60 жилийн ой тохиож буйтай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг даргын мэндчилгээ бүхий 100000 /Зуун мянган/ төгрөгийн дурсгалын зүйлс бэлтгэн 3000000 /Гурван сая/ төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Зардалд шаардагдах нийт 3100000 /Гурван сая нэг зуун мянган/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөцийн хөрөнгөөс гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /О.Мөнхбаяр/-т зөвшөөрсүгэй.

3. Зардлын тайланг 2019 оны 8 дугаар сарын 1-ний дотор гаргаж тайлагнахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга /Д.Лувсандагва/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ